# ХӨВСГӨЛ АЙМГИЙН
# ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 23 өдөр Дугаар А/25 Ханх сум

Ой хээрийн болон объектын гал
түймрээс урьдчилан сэргийлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40 2. 40.2.3, 40.2.4, 40.2.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. аймгийн онцгой комиссын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд ой хээрийн түймэр болон объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1-р хавсралтаар баталсугай.

2. Ой хээрийн болон объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд тусгасан ажиллахыг хэрэгжүүлэн ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн М.Жавзан, Байгаль хамгаалагч Х.Ичинноров нарт үүрэг болгосугай.

3. Өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт сэрэмжлүүлэг хүргэн, хөдөлгөөнт эргүүл томилон ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Баттүвшинд) үүрэг болгосугай.

5. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг байгаль хамгаалах сангаас гаргаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын (Б.Баасансүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Л.ДАВААБАЯР

My doc-2024 Zahiramj

0707000090

Сумын Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 23-ны А/23 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

РОА0001 9071296

## ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах албан хаагч | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Түймрээс урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эрүүл томилох | Багийн засаг дарга нар | 3/20-4/20 |
| 2 | Олон нийтэд мэдээлэл хүргэх гарын авлага тараах, цахим орчинд мэдээлэл хүргэх | Байгаль хамгаалагч, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн М.Жавзан | Өдөр бүр |
| 3 | Ойн сан бүхий газарт түлээ бэлдэх иргэдэд түймрээс сэргийлэх мэдээлэл өгөх | Байгаль хамгаалагч Х.Ичиннэров | Байнга |
| 4 | Хүч, хэрэгслийн судалгаа хийж, тодотгох | Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн М.Жавзан | 4/01-4/20 |
| 5 | Багийн дарга, БОТХБТасаг, Ханх хэсгийн ХУТХГ-н байгаль хамгаалагч нар хамтран эргүүлээр ажиллах, малчин иргэдэд мэдээлэл хүргэх | Багийн дарга, БОТХБТасаг, Ханх хэсгийн ХУТХГ-н байгаль хамгаалагч нар | Тухай бүрт |